



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ БОЛОН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МЭДЭЭЛЭЛ



2022 оны 1-р сард Азийн Эрүүл Мэндийн Газрын удирдах бүрэлдэхүүнд түүхэн өөрчлөлт гарсан юм. Нийт 46 жил гүйцэтгэх захирлын алба хашсан Шерри Хирота ажлаасаа чөлөөлөгдөж, стратегийн асуудал эрхэлсэн захирал болон зөвлөхийн үүрэг гүйцэтгэхээр боллоо. Шерригийн удирдлаган дор олон жил ажилласны дараа Жулиа Лиу Гүйцэтгэх захирлаар, Ту Куач ерөнхийлөгчөөр ажиллахаар удирдлагын багт орсон нь бидний хувьд ннэр төрийн хэрэг юм.

Зүүн гар талаас Азийн Эрүүл Мэндийн Үйлчилгээни Газрын гүйцэтгэх захирал Жулиа Лиуа, Ерөнхийлөгч Ту Куач

Жулиагийн хувьд: Би 22 жилийн өмнө энд ажиллахаар ирэхдээ Азийн Эрүүл Мэндийн Газрын сурталчилгаа болон үйлчилгээний давхар зорилго гүйцэтгэдэгт нь татагдсан билээ. Тайвань, Хонг Конгоос ирсэн цагаачдын охины хувьд англи хэл мэддэггүй цагаач өвөө маань хэлний хүртээмжтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хэрхэн хүртэж байсныг биеэр харсан. Түүний мэдэрсэн эерэг нөлөөллийг би өөрийнхөө ажилд хэрэгжүүлэхийг хүссэн. Би энэ гайхамшигтай байгууллагын нэг хэсэг байхыг хүссэн бөгөөд ингэснээр ажилтнуудтайгаа хамт өвчтөнүүдийнхээ амьдралд эерэг нөлөө үзүүлэх газрыг бий болгохын тулд та бүхэнтэй хамтран ажиллах болно. Энд ажиллаж, өвчтөнүүддээ үйлчлэх, тэдэнд сурталчилгээ үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон нь миний хувьд нэр төрийн хэрэг юм.

Би тав орчим настай байхдаа Вьетнамаас гэр бүлийн хамт ирсэн дүрвэгчийн хувьд манай гэр бүлийнхэн болон Арлингтоны Эрүүл Мэндийн Үйлчилгээний Газрын өвчтөнүүдийн хооронд ижил төстэй зүйл их байгааг олж харлаа. Аав ээж маань англиар ярьдаггүй бөгөөд бид санхүүгийн хувьд хүнд байдалд байлаа. Би 1996 онд коллежид байхдаа өөрийнхөө хэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах санаанд маш их татагдсан учраас Азийн Эрүүл Мэндийн Үйлчилгээний Газарт ажиллаж эхэлсэн юм. Бага байхдаа би эцэг эхийнхээ хэлмэрчээр байнга ажилладаг байсан бөгөөд энэ ачаа бүхэл бүтэн гэр бүлд ямар хүндрэлтэй байдгийг мэдэрдэг байсан. Би 2011 онд Азийн Эрүүл Мэндийн Үйлчилгээний Газарт дахин нэгдсэн бөгөөд өвчтөнүүддээ гүнээ санаа тавьдаг ийм сайхан хамт олонтой энд ажиллаж байгаагаа их нэр төрийн хэрэг хэмээн үздэг байлаа. Гэр бүлд Азийн Эрүүл Мэндийн Үйлчилгээний Газар шиг халамж тавьдаг газар үргэлж байгаасай гэж хүсдэг. Ийм ч учраас би Азийн Эрүүл Мэндийн Үйлчилгээний Газрын үйлчилгээ, сурталчилгааны эрхэм зорилгод үнэнч байдаг.

Эрүүл мэндийн тогтолцоо, үргэлжилж буй цар тахал, өөрчлөгдөж буй эдийн засагтай холбоотой шинэ боломж, сорилтуудтай тулгарсан энэхүү үед бид өвчтөнүүддээ үйлчлэх, сурталчилгээ хийх энэхүү чухал ажлыг хамтдаа хийхээр зорьж байна. Урьдчилан таамаглах аргагүй цаг хугацаанаа үргэлжилсэн бид өвчтөнүүдийнхээ төлөө үргэлж ажиллах болно.

Цахим инноваци: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч, эрүүл байх шинэ арга замууд

Гэрээсээ эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ уулзахыг хүссэн хэн бүхэнд утсаар эрүүл мэндийн үзлэг хийх боломжтой гэдгийг та мэдэж байгаа гэдэгт найдаж байна. Иймээс та биеэр очих эсвэл хүлээлгийн өрөөнд суух шаардлагагүй гэсэн үг!

Бид тантай харилцах харилцаагаа сайжруулж, эрүүл байхад тань туслах технологийг ашиглахыг хүсч байна! Энэхүү ажиллагааны хүрээнд цусны даралт ихэсдэг өвчтнүүддээ зориулан шинэлэг хөтөлбөр хэрэгжүүлж эхэллээ. Бид ухаалаг гар утсанд тань холбогдож болох цусны даралтын аппаратыг танд өгөх болно. Дараа нь таны утас хэмжилтийн үр дүнг бидэнд илгээснээр үйлчилгээ үзүүлэгч тань үр дүнг хялбархнаас харж болно. Та энэхүү үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй байгаа бол үйлчилгээ үзүүлэгчдээ мэдэгдэнэ үү!

Цусны даралтыг хянах програмын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл QR кодыг уншуулна уу. (Заавар: Хэрвээ танд ухаалаг утас байгаа бол камераа нээж, код руу чиглүүлээрэй. Дараа нь гарч ирэх холбоос дээр дарж зааварчилгаа вах видеог YouTube дээрээс үзнэ үү.)



Сармагчны цэцэг өвчний талаар бид юу мэдэх вэ?

Сармагчны цэцэг өвчний эрсдлийн талаарх мэдээлэл:

- Сармагчны цэцэг өвчин одоогоор тийм ч түгээмэл бус байна.
 - 8-р сарын эцсийн байдлаар Аламеда мужийн 1.7 сая оршин суугчдын дунд одоогоор 150 хүрэхгүй тохиолдол
- Иргэдийн хувьд сармагчны цэцэг өвчин тусгах эрсдэл маш бага
 - Олон нийтийн газар харилцан яриа өрнүүлэх, зам хөндлөн гарах гэх мэтээр сармагчны өвчтэй хүнтэй санамсаргүй харьцахад халдвар авах эрсдэлгүй.
- Хүмүүст сармагчны цэцэг өвчин дараах замаар халдаж болно. Үүнд:
 - Халдвар авсан хүний гэмтсэн арьсанд хүрэх
 - Үнсэлт болон бэлгийн харилцаанд орох зэргээр биеийн шингэнд хүрэлцсэн бол
 - Халдвар авсан хүний ор хөнжил, нүүр гарын алчуур зэрэг хэрэгслийг хуваалцсан бол
 - Урт хугацааны нүүр тулан харьцах замаар амьсгалын замын шүүрлийг шингээх, ихэвчлэн сармагчны өвчнөөр өвчилсөн хүнтэй хамт амьдрах/асрах
- Хэдийгээр сармагчны цэцэг өвчнөөр хэн ч өвдөж болох ч энэ үед уг өвчин нь эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн олон нийтийн сүлжээ / бүлэгт илүү их нөлөөлж байна. Үүний үр дүнд энэ бүлгийн хувь хүмүүс уг өвчлөлд өртөх эрсдэл өндөр байна.


Сармагчны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замууд:

- Бие дээрээ яр, шархтай хүмүүстэй тэврэлдэх, хүрэх, бэлгийн хавьталд орохоос зайлсхийх.

- Шинж тэмдэг илэрсэн хүнтэй эд зүйлс (жишээлбэл, сав суулга, аяга, хувцас, алчуур, ор дэрний цагаан хэрэглэл) хуваалцахгүй байх.
- Гараа ус, савангаар угааж, шинж тэмдэг илэрсэн хүнтэй хавьталд орсон бол спиртен суурьтай ариутгагчаар цэвэрлэж, ариутга.
- Шинж тэмдэг илэрсэн хүнийг арчлах бол амны хаалт зүүж, бээлийг өмсөөрэй.

Сармагчны цэцэг өвчний шинж тэмдгүүд:

- Халуурч, тунгалгийн зангилаанууд тодорч, бие өвдөж, ханиалгах
- Улайлт нь дараах дарааллаар хавдаж, хамуурна:



Та өөрийгөө сармагчны цэцэг өвчний халдвар авсан хэмээн сэжиглэж байвал:

- Гэрээсээ гаралгүй, тусдаа өрөөнд өөрийгөө тусгаарлаад
- Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ холбогдоно уу.

Сармагчны цэцэг өвчнөөр өвчилсөн хүнтэй харьцсан эсвэл халдварт өртөх өндөр эрсдэлтэй нийгмийн сүлжээ/нийтэд байгаа хүмүүс:

- Халдвар авахаас сэргийлэхийн тулд JYNNEOS вакцин хийлгэх талаар эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ холбоо барина уу.
- Сармагчны цэцэг өвчний эсрэг вакцин одоогоор маш хязгаарлагдмал нөөцтэй байна. Үүнийг зөвхөн эрүүл мэндийн ажилтнууд, сармагчингийн халдварт өртсөн хүмүүс, эсвэл өндөр эрсдэлтэй эрэгтэйчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүд болон ХДХВ-ийн халдвартай трансжендер хүмүүст хийж байгаа болно.

2022 оны бүх нийтийн сонгууль

Та 2022 оны 11-р сарын 8-нд өөрчлөлт хийхэд бэлэн үү? Дахин санал өгөх цаг болсон бөгөөд Арлингтоны Эрүүл Мэндийн Газрын үйлчлүүлэгчид энэ дунд хугацааны сонгуульд чухал шийдвэр гаргах ёстой. Учир нь бид манай хот, муж улс, тойргийн засаг захиргааг хэн удирдахыг шийдэх зэрэг бидэнд чухал ач холбогдол бүхий олон зүйлийг бодолцох хэрэгтэй болно.

Дунд шатны сонгууль юунд нөлөөлж болох вэ? Хотын дарга, засаг дарга зэрэг төрийн болон орон нутгийн албан тушаалтнуудын төлөө санал өгөхдөө бид сургуулийн санхүүжилт, хямд төсөр орон сууц, эрүүл мэндийн даатгал зэрэг асуудлаар шийдвэр гаргаж байдаг.

Ази гаралтай америкчуудын тоо мэдэгдэхүйцээр өсч, бид санал өгөх эрх мэдэлтэй болсон. 2020 оны ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Ази гаралтай америкчуудын сонгогчийн ирц хамгийн их өссөн бөгөөд 2014 онд 49.3% байсан бол 2020 онд 59.5% болсон билээ. Иймд санал өгөхөөр шийдвэл бид сонгуульд үнэхээр нөлөөлж чадна гэсэн үг юм.

Хэрвээ та 18 нас хүрсэн иргэн бол санал өгөхөөр бүртгүүлсэн эсэхээ санаж шалгаарай. Калифорнийн бүртгэлтэй бүх сонгогч 11-р сарын 8-нд болох бүх нийтийн сонгуулийн саналын хуудсыг шуудангаар хүлээн авах болно. Дүүргийн тань сонгуулийн алба 2022 оны 10-р сарын 10-ны дотор саналын хуудсыг шуудангаар илгээх юм. Та саналын хуудсаа Арлингтоны Эрүүл Мэндийн Газарт өгөх боломжтой.

Энэхүү бүх нийтийн сонгуульд **санал өгөхөөр бүртгүүлэх** сүүлийн өдөр бол 2022 оны 10-р сарын 24 юм. Санал өгөхөөр бүртгүүлэх эсвэл бүртгүүлсэн эсэхээ эндээс шалгана уу:



Ваше избирательное право

Гишүүнчлэлийн шинэчлэл

Өндөр настай болон бичиг баримтгүй хүмүүс

- 2022 оны 5-р сарын 1-с эхлэн 50 болон түүнээс дээш насныхан цагаачлалын байдлаасаа үл шалтгаалан Medi-Cal-н үйлчилгээнд хамрагдах болсон.

MAGI бус Medi-Cal хөтөлбөрүүдийн хөрөнгийн хязгаарлалтын өөрчлөлт

- 2022 оны 07-р сарын 01-ний өдрөөс эхлэн хөрөнгийн хязгаар нэг хүнд 2000 доллараас 130,000 доллар болж, гэр бүлийн нэмэлт гишүүн бүрт 65,000 доллар хүртэл нэмэгдэв.
- Эдгээр хөрөнгийн шинэ хязгаар нь дараах хөтөлбөрт хамаарна:

Medi-Cal Хөтөлбөрийн хөрөнгийн хязгаар	
Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийн мэдээлэл
Өндөр настан, Хараагүй болон Хөгжлийн Бэрхшээлтэй иргэдэд зориулсан Холбооны Ядуурлын Эсрэг Хөтөлбөр	65-аас дээш насны хөгжлийн бэрхшээлтэй, хараагүй хүмүүс энэхүү хөтөлбөр үнэгүй
250% Ажилтай Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Хөтөлбөр	Хөгжлийн бэрхшээлтэй боловч, ажил хөдөлмөр эрхэлдэг иргэдэд зориулсан хөтөлбөр
Урт Хугацааны Халамжийн Хөтөлбөр	Удаан хугацааны эрүүл мэндийн тусламжийн байгууллагад хэвтэж буй иргэдэд зориулсан хөтөлбөр
Төрөөс Зардлыг нь Хэсэгчлэн Даадаг Өвчтний Хөтөлбөр	Энэхүү хөтөлбөр нь 65-с дээш настай иргэд, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл хараагүй хүмүүст зориулагдсан. Энэхүү хөтөлбөрт хамрагдахын тулд сар бүр төлбөр төлдөг.
Medicare Хуримтлалын Хөтөлбөр	Medicare-т хамрагддаг хүмүүст зориулсан хөтөлбөр. Эдгээр хөтөлбөр нь таны Medicare зардлыг хуваалцах, эсвэл олговор олгох зэрэг арга замаар танд тусалдаг.

Хэрвээ та Medicare-т хамрагдах шаардлага хангаагүй бол **COVERED CALIFORNIA** нь танд байж болох өөр нэг хувилбар юм. Энэ нь шаардлага хангасан иргэд болон жижиг бизнесийнхэнд холбооны засгийн газрын татаас бүхий хөнгөлөлтэй үнэ олгодог эрүүл мэндийн даатгалын систем юм. Үүнд дөрвөн төрлийн метал давхарга бий. Үүнд Хүрэл, Мөнгө, Алт, Платинум зэрэг ордог.

Манай үйлчлүүлэгч болох эсвэл CalFresh-т хамрагдахыг хүсч байвал,

510-986-6880-р залгах буюу 1818 Webster St, Oakland CA 94607 хаягаар ирж уулзах болон | membersvcgrp@ahschc.org хаягаар цахим шуудан явуулж болно
(Даваагаас Баасан гарагт: 9am – 5pm хүртэл ажиллах бөгөөд үдийн хоолны цаг 12pm-1pm)

COVID шинэчлэл

КОВИД-19-н вакцин –

Цаг товлохын тулд 510-735-3222 руу залгана уу.

КОВИД-19-н шинжилгээ - Цаг товлохын тулд: 510-735-3222 руу залгаарай, эсвэл QR кодыг сканнердаж болно.



Цагийн хуваарь

Даваа гараг	Клинтон парк 1-4PM 655 International Blvd. Oakland, CA
Мягмар гараг	AHS эмнэлэг 9:15AM – 4PM 416 8 th St. Oakland, CA
Лхагва гараг	AHS эмнэлэг 1:30PM – 4PM 416 8 th St. Oakland, CA
Баасан гараг	AHS эмнэлэг 9:15AM – 4PM 416 8 th St. Oakland, CA

Цагийн хуваарь

Monday	Клинтон парк 1-4PM 655 International Blvd. Oakland, CA
Tuesday	Уилма Чан Парк 8:30AM – 4PM 810 Jackson St. Oakland, CA
Wednesday	Уилма Чан Парк 1PM – 4PM 810 Jackson St. Oakland, CA
Thursday	Уилма Чан Парк 8:30AM – 4PM 810 Jackson St. Oakland, CA

Шинжилгээний талаарх түгээмэл асуултын хариу - Би хэзээ PCR эсвэл эсрэг биетийн шинжилгээ өгөх ёстой вэ?

PCR нь Полимеразын гинжин урвал гэсэн үг бөгөөд вирусын генетик мэдээллийн жижиг үл мөрийг илрүүлдэг. Ашиглах хамгийн тохиромжтой цаг: шинж тэмдэггүй, эерэг үр дүн гарсны дараа 6 дахь өдөр тусгаарлах хугацаа дуусна

Антигенийн шинжилгээ нь коронавирусын уураг илрүүлдэг бөгөөд илрүүлэхийн тулд илүү их хэмжээний вирус шаарддаг. Хэзээ хэрэглэхэд хамгийн тохиромжтой цаг: шинж тэмдэг илэрсэн, эерэг үр дүн гарсны дараа 6 дахь өдөр тусгаарлах хугацаа дуусах хүртэл шинжилгээ



101 8th Street, Suite 100
Oakland, CA 94607

Non-Profit
Org. US
Postage PAID
Oakland, CA
Permit No.
3630

Ханиадны улирал эхэллээ!

Томуу(томуу төст)-гийн вирус нь ихэвчлэн намрын сүүлээс хаврын эхэн үе хүртэл тархдаг. Энэхүү ноцтой өвчнийг тусах, тэр байтугай нас барах эрсдэлтэй хүмүүс бол бага насны хүүхдүүд, жирэмсэн эмэгтэйчүүд, өндөр настай болон архаг хууч өвчтэй хүмүүс юм.

Энэхүү өвчнөөс өөрийгөө хэрхэн хамгаалах вэ?

- Томуугийн вакцин хийлгэх. Зургаан сараас дээш настай хүн бүр томуугийн вакцин хийлгэвэл зохино. 10-р сараас эхлэн томуугийн вакцин хийлгэхийн тулд (510) 735-3222 руу залгаж цаг товлоорой.

ОЛОН НИЙТИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ САНААЧЛАГА

2021 онд Азийн Эрүүл Мэндийн Үйлчилгээний Газар нь өвчтөн, ажилтнууд болон олон нийтэд нөлөөлж буй гэмт хэрэг, үзэн ядалтаас үүдсэн үйлдлүүдийн хариуд Олон нийтийн Эмчилгээний Санаачилга (СНІ) хөтөлбөрийг бий болгосон билээ. Хөтөлбөрийн зорилго нь хүчирхийллийг бууруулах, эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаагаар өвчтний эдгэрэлтийг дэмжих явдал юм. СНІ-ийн цогц эдгээх арга барил нь дахин гэмтэл авахаас урьдчилан сэргийлэх, соёлын аргаар эдгэрэлтийг дэмжих байнгын үйл ажиллагаа юм. Сүүлийн үед бид Zoom-ээр долоо хоног бүр үнэгүй виртуал йогийн хичээлүүдийг санал болгодог Кантоны йогийн багш Сасанна Еетэй хамтран ажиллаж байна. СНІ нь манай Азийн нийгэмлэгийн гишүүдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эмчлэх, сэргээх өвөрмөц бөгөөд цогц арга барилыг хэрэгжүүлдэг.

Манай үйлчилгээ нь эдгээх үйл явцын зөвхөн нэг хэсэг юм; Хүн бүр жижиг, утга учиртай аргаар гэмт хэрэгт өртсөн хүмүүсийг дэмжих боломжтой. Та амьд үлдсэн хүмүүсийг дараах байдлаар дэмжиж болно:

- Тэдэн рүү залгаж, яаж байгааг нь асуух
- Тэд өөрсдийгөө бусдаас тусгаарлаж байгаа эсэхийг шалгах
- Тэднийг зохих, мэргэжлийн тусламжтай холбож эдгээх үйл явцыг нь дэмжих.

Хэрвээ танд болон ойр дотны хүнд тань хохирогчийг дэмжих үйлчилгээ хэрэгтэй бол СНІ хуудаснаас харж, бидэнтэй холбогдож нэмэлт мэдээлэл авна уу.

Дэлгэрэнгүй мэдээллийг 510-735-3940 дугаараар бидэнтэй холбогдон авна уу